

2433/ 4

ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА,
МОНГОЛЫН ХӨГЖИЙН ЗОХИОЛЧДЫН ХОЛ-
БООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН
ХУРЛЫН ТОГТООЛ

1976 оны I дүгээр
сарын 8-ний өдөр

Дугаар I

Улаанбаатар
хот

БОЛЗОЛ БАТЛАХ ТУХАЙ

Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Монголын хөгжмийн зохиолчдын холбооны нарийн бичгийн дарга нарын хурлаас ТОГТООХ нь:

I. Улаанбаатар хотод нээгдэж байгаа хуримын ёслолын хөгжим зохиох уралдааныг хөгжмийн зохиолчдын дунд 1976 оны I-р сараас 3-р сарын I-нийг хүртэл хугацаагаар заралсугай.

2. Хуримын ёслолын хөгжмийн уралдааны болзлыг баталсугай.

3. Уралдааны шагналыг 1976 оны бэлтгэл хөрөнгөнөөс гаргахыг Хотын гүйцэтгэх захиргааны аж ахуйн хэлтэс /н. Алтангэрэл/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ I-Р
ОРЛОГЧ
ДАРГА

М.ДУГАРЖАВ

МОНГОЛЫН ХӨГЖИЙН ЗОХИОЛЧДЫН
ХОЛБООНЫ
ДАРГА

С.ГОНЧИГСУМЛАА

УРАЛДААНЫ БОЛЗОЛ

Улаанбаатар хотод нээгдэж байгаа хуримын ордны ёслолын ажиллагаанд эгшиглэх хөгжим зохиох уралдааныг хөгжмийн зохиолчдын дунд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Монголын хөгжмийн зохиолчдын холбооноос зарлаж байна.

Хөгжим нь 2 хэсэгтэй байна.

1-р хэсэг. Ёслолын эхлэлийн хэсэг I минутаас багагүй хэмжээтэй хөгжүүлэн баяр баясгалантай байна.

Энэ хөгжмийн аянд залуу хос ёслолын танхимд орж ирнэ.

2-р хэсэг. Ёслолын хэсэг I минут хагасын хугацаатай байна.

Энэ хөгжим залуу хосыг гэр бүлийн баталгаа хүлээж авахад эгшиглэнэ.

Аялгуу нь хөгжүүн баяр баясгалантай байх ба нийт хугацаа хоёр минутаас хагас орчим байна.

Шагнал 1-р байр I	1500 төгрөг
2-р байр I	1000 төгрөг
3-р байр I	800 төгрөг

Зохиогч уран бүтээлийнхээ шагналыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолын дагуу жич авна.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГАА, МОНГОЛЫН ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ-
ДЫН ХОЛБОО